



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/199

Эг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.3 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.3.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.12.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Хамтын хүч нөхөрлөлийн ойн санд "Оргил буман од" ХХК-ны 2023 онд хийсэн ойжуулалтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд

Ажлын хэсгийн ахлагч: Н.Шажинбат- Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Б.Батчимэг –Сум дундын Ойн ангийн ойн техникч

Гишүүд: Д.Хонгорзул- Онон багийн Засаг дарга

Б.Мөнх-Очир- Байгаль орчны хяналтын улсын
байцаагч

Б.Болд- Байгаль хамгаалагч

2. Ойжуулалтын ажлыг хууль журмын дагуу зохион байгуулж 2024 оны 7 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Шажинбат)-д үүрэг болгосугай.

3. Дээрх үйл ажиллагаанд зарцуулах шатахуун тослох материал, бусад зардлыг тооцоолж, санхүүгийн баримтыг бүрдүүлж ажиллахыг "Оргил буман од" ХХК-ны Захирал (Г.Баярсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНСҮХ

232401199